

“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ-2025” АРГА ХЭМЖЭЭГ ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2025.06.15

Арвайхээр

Монгол Улсын сайд, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ХЭГ/1122 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээг хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлэх, төрийн хэт оролцоо, хүнд суртлыг арилгах зорилгоор “И-Бизнес” бизнес эрхлэгчдэд зориулсан платформыг таниулан сурталчлах хүрээнд долоо хоногийн турш нээлттэй засгийн түншлэлийн 10 үнэт зүйл, тогтвортой хөгжлийн 17 зорилтыг таниулах чиглэлээр доорх арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

1. “Суралцагч хот” нээлттэй хаалганы өдөрлөг

Аймгийн төв талбайд “Суралцагч хот-Арвайхээр” өдөрлөгийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Насан туршийн суралцахуйн төв, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, болон төр, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. “Суралцагч хот” хөтөлбөрийн эрхэм зорилго нь бүх иргэнээ насан туршид суралцах боломжоор хангаж, мэдлэг, ур чадварыг нь хөгжүүлж, хотын эдийн засаг, нийгмийн хөгжилд эерэг өөрчлөлт бий болгоход оршиж буй юм. Өдөрлөгийн үеэр “Эрүүл амьдралын хэв маягт суралцацгаая”, “Тархи оюунаа цэнэглэхэд суралцацгаая”, “Байгаль дэлхийгээ хайрлаж суралцацгаая”, “Санхүүд суралцацгаая”, “Урлаг, соёлд суралцацгаая”, “Өв соёлоосоо суралцацгаая” өртөөнүүдийн 20 гаруй төрлийн үйл ажиллагаанд 600 гаруй иргэд оролцож, өөрсдийн сонирхсон сэдвээрээ суралцав.



Нээлттэй хаалганы өдөрлөг

2. “Ажил олгогч, даатгуулагчдын зөвлөгөөн-2025” нэгдсэн зөвлөгөөн

Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Нийгмийн даатгалын газраас хамтран “Ажил олгогч, даатгуулагчдын зөвлөгөөн-2025”-ийг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнөөр нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд, даатгуулагчдад нэгдсэн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд зөвлөгөөнд 19 сумын 400 гаруй иргэн, даатгуулагч оролцлоо. Мөн зөвлөгөөний үеэр шилдэг даатгуулагч аж ахуй нэгж, иргэдийг шагнаж урамшууллаа.



“Ажил олгогч, даатгуулагчдын зөвлөгөөн-2025”

3. “Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр

Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Хархорин суманд “Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдрийг 2025 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг нь тус өдөрлөгөөр дараах үйл ажилагааг зохион байгуулан ажилласан. Үүнд: Сум дундын Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 423 дугаар нээлттэй хаалттай хорих анги, Прокурорын газар, Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, Орхон сургуулийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Төрийн байгууллагуудын удирдах, гүйцэтгэх 160 гаруй албан хаагчийг хүний эрхэд суурилсан хандлагаар төрийн үйлчилгээг хүргэх мэдлэг ойлголт, арга зүйг дээшлүүлэх сургалтад хамруулснаас гадна хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, иргэдийг оролцуулан хүний эрхийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.



Хууль сахиулах байгууллагын удирдлага, төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн 6 дугаар бүлэг “Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт”-ийн талаарх мэдээллийг хүргэж, санал солилцлоо. Уулзалтад хууль хяналтын байгууллагуудын удирдлагууд, албан хаагч 40 гаруй хүн оролцсон.



“Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр

4. “Бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийн оролцоо” зөвлөлдөх уулзалт

Цахим засаглалыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй үр дүнтэй хүргэх зорилтын хүрээнд Цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд мэдээллийн технологи, харилцаа холбооны ажилтнуудын боломж ба бэрхшээл, хамтын манлайлал сэдвээр сургалт болж өндөрлөв. Энэхүү сургалтад нийт 53 мэдээлэл, технологийн ажилтан, харилцаа холбооны салбар, мэдээллийн технологийн багш нарын төлөөлөл хамрагдсан юм.




Нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх сэтгэлгээтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн чиглэлээр суралцах сонирхолтой хүүхдүүдийг дэмжих бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилготой ХУРДАН клубийн нээлтийн үйл ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв хамтран 16 өсвөр үеийн сурагч, 12 ахмад настан 5 хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийт 33 гишүүн “Батламж” гардан авч “ХУРДАН” клуб байгуулагдсан.



“Бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийн оролцоо” зөвлөлдөх уулзалт


"Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025" арга хэмжээний хөтөлбөрийн дагуу Сонгуулийн ерөнхий хороотой хамтран “Нээлттэй засгийн сорилт: Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал” сэдэвт видео танилцуулгыг үзэж, тайлангийн цахим системийн хөгжүүлэлт дээр хамтран ажиллах мэдлэг олж авлаа.

Мөн Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Бизнес ба хүний эрх” цахим сургалтад аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага, мэргэжилтнүүд хамрагдаж, НҮБ-ын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын тухай мэдлэг, ойлголттой боллоо.



Сургалтад хамрагдсан байдал

Дээрх арга хэмжээнүүдийг аймгийн албан ёсны <https://uvurkhangai.gov.mn/> сайт, фэйж хуудас, холбогдох агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон улс, орон нутгийн хэвлэл мэдээллийн сувгуудаар олон нийтэд, мэдээлж сурталчилж ажиллалаа.



Вэб сайтад байршуулсан байдал

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР